## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **210,056,843.47** | **235,355,967.51** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 210,056,843.47 | 235,355,967.51 |
| **351** | **Түүхий эд материал** | 7,492,480.00 | 10,755,435.00 |
| 35130 | Эм боох материал | 7,492,480.00 | 10,755,435.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 202,564,363.47 | 224,600,532.51 |
| 35420 | Аж ахуйн материал | 12,580,305.00 | 15,977,300.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 189,984,058.47 | 208,623,232.51 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,940,529,236.16** | **5,200,122,347.26** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,940,529,236.16 | 5,200,122,347.26 |
| **392** | **Биет хөрөнгө** | 921,304,236.16 | 4,179,884,847.26 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 736,976,452.20 | 3,841,900,785.20 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -133,648,267.20 | -225,670,714.08 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 378,478,718.62 | 325,473,642.50 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -296,882,626.39 | -54,025,095.94 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 179,978,796.57 | 244,939,491.49 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -65,535,715.01 | -82,213,333.95 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 55,911,689.98 | 92,354,146.98 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -23,326,601.68 | -30,176,976.30 |
| 39217 | Ном | 89,351,789.07 | 67,302,901.36 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 1,019,225,000.00 | 1,020,237,500.00 |
| 39301 | Програм хангамж | 1,260,000.00 | 1,012,500.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,019,225,000.00 | 1,019,225,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,150,586,079.63** | **5,435,478,314.77** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,150,586,079.63** | **5,435,478,314.77** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,150,586,079.63 | 5,435,478,314.77 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,278,163,442.40 | 2,278,163,442.40 |
| 51101 | Өмч: - төрийн | 2,278,163,442.40 | 2,278,163,442.40 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -758,928,923.15 | 2,525,963,311.99 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -758,928,923.15 | -758,928,923.15 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 3,284,892,235.14 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 631,351,560.38 | 631,351,560.38 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,150,586,079.63** | **5,435,478,314.77** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,126,653,689.30** | **6,608,437,120.93** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,682,138,789.30** | **5,978,951,093.66** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 179,806,989.30 | 3,419,208,593.66 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 179,806,989.30 | 3,419,208,593.66 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 40,018,500.00 | 26,735,150.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 139,788,489.30 | 3,392,473,443.66 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 2,502,331,800.00 | 2,559,742,500.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 2,502,331,800.00 | 2,559,742,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **444,514,900.00** | **629,486,027.27** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 705,000.00 | 32,076,827.27 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 100,000.00 | 21,893,327.27 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 605,000.00 | 8,633,500.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | 00.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 443,809,900.00 | 597,409,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 443,809,900.00 | 597,409,200.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3,065,359,629.05** | **3,285,480,725.48** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,065,359,629.05** | **3,285,480,725.48** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,858,862,611.70 | 3,199,897,424.81 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,017,323,666.00 | 2,035,524,874.78 |
| 210101 | Үндсэн цалин | 1,606,614,746.00 | 1,775,155,738.96 |
| 210102 | Нэмэгдэл | 254,960,020.00 | 204,012,910.74 |
| 210104 | Урамшуулал | 155,748,900.00 | 56,356,225.08 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 252,975,219.00 | 287,895,700.15 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 172,186,514.00 | 204,192,723.48 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 20,257,237.00 | 23,348,996.82 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 16,185,630.00 | 18,005,296.01 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,031,439.00 | 5,205,674.36 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 40,314,399.00 | 37,143,009.48 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 353,520,262.40 | 548,890,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,229,326.40 | 7,043,975.90 |
| 210302 | Түлш, халаалт | 335,586,022.00 | 526,390,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,704,914.00 | 15,456,024.10 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 39,599,690.25 | 31,654,706.67 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,467,800.00 | 4,508,227.27 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,000,000.00 | 7,543,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 984,575.25 | 1,156,774.40 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4,263,820.00 | 3,788,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 24,883,495.00 | 14,658,205.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 4,622,470.00 | 13,586,010.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,630,470.00 | 9,734,810.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,992,000.00 | 3,851,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 20,000,000.00 | 53,892,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 20,000,000.00 | 53,892,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 600,000.00 | 1,937,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 600,000.00 | 1,937,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,867,300.00 | 21,933,951.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,267,300.00 | 20,925,951.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | 1,008,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 166,354,004.05 | 204,582,082.21 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 28,051,350.00 | 52,527,110.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 138,302,654.05 | 152,054,972.21 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 206,497,017.35 | 85,583,300.67 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 60,390,600.00 | 84,583,000.00 |
| 213205 | Тэрээс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 56,402,100.00 | 82,353,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,988,500.00 | 2,230,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 70,289,637.60 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 70,289,637.60 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 75,816,779.75 | 1,000,300.67 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 75,816,779.75 | 1,000,300.67 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **61,294,060.25** | **3,322,956,395.45** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 9,593,159.67 | 38,064,160.31 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 9,593,159.67 | 38,064,160.31 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -9,593,159.67 | -38,064,160.31 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **51,700,900.58** | **3,284,892,235.14** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| С 08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,278,163,442.40** | **631,351,560.38** | **-758,928,923.15** | 2,150,586,079.63 |
| D 01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,278,163,442.40** | **631,351,560.38** | **-758,928,923.15** | 2,150,586,079.63 |
| D 03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,278,163,442.40** | **631,351,560.38** | **-758,928,923.15** | 2,150,586,079.63 |
| D 08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 3,284,892,235.14 | 3,284,892,235.14 |
| D 09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,278,163,442.40** | **631,351,560.38** | **2,525,963,311.99** | 5,435,478,314.77 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **3,000,284,300.00** | **3,226,407,188.27** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,542,350,300.00** | **2,586,477,650.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 40,018,500.00 | 26,735,150.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 40,018,500.00 | 26,735,150.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 40,018,500.00 | 26,735,150.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 2,502,331,800.00 | 2,559,742,500.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 2,502,331,800.00 | 2,559,742,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **457,934,000.00** | **639,929,538.27** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 14,124,100.00 | 42,520,338.27 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 1,550,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 13,519,100.00 | 22,751,638.27 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 605,000.00 | 18,218,700.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 443,809,900.00 | 597,409,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 443,809,900.00 | 597,409,200.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,960,617,000.00** | **3,133,672,588.27** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,960,617,000.00** | **3,133,672,588.27** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,754,124,982.65** | **3,048,089,287.60** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,000,708,285.00 | 2,046,841,574.93 |
| 210101 | Үндсэн цалин | 1,589,999,385.00 | 1,489,582,174.93 |
| 210102 | Нэмэгдэл | 254,960,000.00 | 431,159,400.00 |
| 210104 | Урамшуулал | 155,748,900.00 | 126,100,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 269,595,600.00 | 276,579,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 189,567,300.00 | 194,629,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 20,007,000.00 | 20,487,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 16,005,700.00 | 16,389,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,001,400.00 | 4,097,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 40,014,200.00 | 40,974,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 353,520,262.40 | 548,890,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,229,326.40 | 7,043,975.90 |
| 210302 | Түлш, халаалт | 335,586,022.00 | 526,390,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,704,914.00 | 15,456,024.10 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 54,575,295.25 | 48,167,912.67 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,580,800.00 | 4,531,227.27 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,000,000.00 | 7,300,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,064,775.25 | 1,156,774.40 |
| 210404 | Ном, хэвлэл | 13,419,100.00 | 9,585,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4,263,820.00 | 4,646,311.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 25,246,800.00 | 20,948,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 13,192,590.00 | 10,742,400.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 10,091,390.00 | 7,498,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,101,200.00 | 3,244,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 20,000,000.00 | 52,359,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 20,000,000.00 | 52,359,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 600,000.00 | 1,937,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 600,000.00 | 1,937,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,867,300.00 | 21,439,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,267,300.00 | 20,431,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | 1,008,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 38,065,650.00 | 41,131,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 38,065,650.00 | 41,131,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **206,492,017.35** | **85,583,300.67** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 60,385,600.00 | 84,583,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 56,402,100.00 | 82,353,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,983,500.00 | 2,230,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 75,816,779.75 | 1,000,300.67 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 75,816,779.75 | 1,000,300.67 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **39,667,300.00** | **92,734,600.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **39,667,300.00** | **92,734,600.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **39,667,300.00** | **92,734,600.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 39,667,300.00 | 92,734,600.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 39,667,300.00 | 92,734,600.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-39,667,300.00** | **-92,734,600.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **0.00** | **0.00** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **0.00** | **0.00** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **0.00** | **0.00** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 3,187,251,700.00 | 3,182,886,549.33 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 3,187,251,700.00 | 3,182,886,549.33 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,101,668,400.00 | 3,098,303,549.33 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,048,733,300.00 | 2,046,841,574.93 |
| 210101 | Үндсэн цалин | 1,491,473,900.00 | 1,489,582,174.93 |
| 210102 | Нэмэгдэл | 431,159,400.00 | 431,159,400.00 |
| 210104 | Урамшуулал | 126,100,000.00 | 126,100,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 276,579,000.00 | 276,579,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 194,629,700.00 | 194,629,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 20,487,300.00 | 20,487,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 16,389,900.00 | 16,389,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,097,400.00 | 4,097,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 40,974,700.00 | 40,974,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 548,890,200.00 | 548,890,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,000,000.00 | 7,043,975.90 |
| 210302 | Түлш, халаалт | 526,390,200.00 | 526,390,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 14,500,000.00 | 15,456,024.10 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 39,514,700.00 | 38,420,174.40 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,542,900.00 | 2,542,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,300,000.00 | 7,300,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,092,900.00 | 1,156,774.40 |
| 210404 | Ном, хэвлэл | 4,244,100.00 | 4,244,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,386,400.00 | 2,228,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 20,948,400.00 | 20,948,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 10,742,400.00 | 10,742,400.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 7,498,400.00 | 7,498,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,244,000.00 | 3,244,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 127,745,000.00 | 127,745,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 59,266,000.00 | 59,266,000.00 |
| 210602 | Тавилга | 19,960,000.00 | 19,960,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 48,519,000.00 | 48,519,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,939,300.00 | 1,937,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,939,300.00 | 1,937,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,542,600.00 | 5,165,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,534,600.00 | 4,157,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,008,000.00 | 1,008,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 41,981,900.00 | 41,981,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 41,981,900.00 | 41,981,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 85583300.00 | 84,583,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 85,583,300.00 | 84,583,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 83,353,300.00 | 82,353,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,230,000.00 | 2,230,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 3,187,251,700.00 | 3,182,886,549.33 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 597,409,200.00 | 597,409,200.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 597,409,200.00 | 597,409,200.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 30,100,000.00 | 26,735,150.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 30,100,000.00 | 26,735,150.00 |
| **122** | **ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ** | 2,559,742,500.00 | 2,558,742,199.33 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 2,559,742,500.00 | 2,558,742,199.33 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 152 | 152 |
| 620001 | Удирдах ажилтан | 01 | 01 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 119 | 119 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 32 | 32 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 2,607 | 2,607 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 2,607 | 2,607 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 2,607 | 2,607 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **42,520,338.27** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **42,520,338.27** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 42,520,338.27 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13,991,838.27 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,988,327.27 |
| 210404 | Ном, хэвлэл | 9,585,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,418,311.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,840,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,840,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 18,838,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 18,838,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5850000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,190,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,660,000.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 42520338.27 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 42,520,338.27 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,550,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 22,751,638.27 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 18,218,700.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Бизкон Аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Мөнхбаяр, туслах аудитор Б.Түмэндэмбэрэл нар гүйцэтгэж, хяналтыг Бизкон аудит ХХК-ийн захирал Л.Отгонбаяр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг аудитын

менежер Э.Бат-Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Бизкон аудит компанийн Хөвсгөл аймаг дахь салбарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Дэлгэрмөрөн цогцолбор сургууль нь бага, дунд боловсролын үйл ажиллагаа явуулдаг Хөвсгөл аймгийн Мөрөн сумын засаг даргын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хөвсгөл аймгийн засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/375 захирамжаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тус байгууллага нь мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Дэлгэрмөрөн цогцолбор сургууль 2021 оны А/23 тоот тушаалаар дотоод хяналт шалгалтын зөвлөлийн нэгж ажилтныг 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна. Тайлант онд 4 ажил гүйцэтгэхээр төлөвлөгөө батлуулан ажиллаж дотоод хяналтыг хангалттай хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,065.3 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 62.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг

байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 49.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж төлөвлөлтийн шатанд суурь үзүүлэлтийг өмнөх оны санхүүгийн тайлангийн дүнг ашигласан тул гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,285.0 сая төгрөгөөр буюу 39.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгө, бараа материалын дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 00 | 00 | 00 |
| Авлага | 00 | 00 | 00 |
| Урьдчилгаа | 00 | 00 | 00 |
| Бараа материал | 210.0 | 235.4 | 25.4 |
| Үндсэн хөрөнгө | 1,940.5 | 5,200.1 | 3,259.6 |
| **Нийт хөрөнгө** | 2,150.5 | 5,435.5 | 3,285.0 |
| Өр төлбөр | 00 | 00 | 00 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 2,150.5 | 5,435.5 | 3,285.0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 2,150.5 | 5,435.5 | 3,285.0 |

БШУЯ-аас тус сургуульд 320 хүүхдийн хичээлийн барилга 3,105.4 сая төгрөг, 39.4 сая төгрөгний явган хүний зам талбай нийтийн эзэмшлийн хөрөнгө, 14.6 сая төгрөгний техник хэрэгсэл, 41.8 сая төгрөгний гал тогооны тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, 10 ангийн багш, сурагчийн ширээ сандал, 19.1 сая төгрөгний бусад хангамжийн материалыг Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 06 дугаар 25-ны өдрийн 71 дүгээр тогтоолыг үндэслэн орлогот авч данс бүртгэлд тусгасан байна.

Мөн Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2021 оны 09 дугаар сарын 10-ны өдрийн А/97 тоот тушаал, БШУЯ-ны "Хөрөнгө оруулалтыг бүртгэх тухай" 2021 оны 09 дүгээр сарын 29-ий өдрийн 6/4966 албан бичиг, Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны А/608 дугаар захирамжийг үндэслэн үндсэн хөрөнгө, багаж хэрэгсэл, тавилга эд хогшил авч бүртгэлд тусгасан байна.
Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн "Үндсэн хөрөнгө худалдах, актлах, шилжүүлэх тухай" 109 дүгээр тогтоол, Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 1/1267 албан бичиг, Мөрөн сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 202 оны 39 дүгээр тогтоол зэргийг үндэслэн сургалтын шаардлага хангахгүй үндсэн хөрөнгө, бараа материалыг данснаас хасч актласан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,553.5 сая төгрөгөөр төлөвлөж санал хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн саналаас 3.9 сая төгрөгөөр бууруулж 2,952.8 сая төгрөгөөр 2021 оны төсвийг баталсан байна. Тус байгууллага нь тайлант онд шаардлагатай зардлуудад 4 удаа 234.4 сая төгрөгөөр төсвийг нэмэгдүүлсэн зохицуулалт, тодотголыг хийлгэж санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,187.2 сая төгрөг болгосон байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааны хүрээнд 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,187.2 сая төгрөгийн төсөв баталсан ба 2,559.7 сая төгрөгийг улсын төсвийн хөрөнгөөр, 597.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөр, 30.1 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны хүрээнд улсын төсвөөс 2,558.7 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 597.4 сая төгрөгийн санхүүжилт, өөрийн орлогоор 26.7 сая төгрөг, нийт 3,182.9 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж хөрөнгийн болон урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулж, 1.0 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,182.9 сая төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь хангамж бараа материал 97.2 хувийн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр зардал 93.2 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь гол нөлөө үзүүлсэн байна. Хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хүснэгтээр харуулбал:

***Хүснэгт2. Төсвийн гүйцэтгэлийн тайлан /үндсэн/ /сая төгрөг/***

| № | 1 хөтөлбөр, 5 арга хэмжээ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | ХӨТӨЛБӨР 71802 | - | - | - | - |
| 1 | 80109-ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал | 597.4 | 597.4 | - | 100 |
| 2 | 80802-АЖИЛ ОЛГОГЧООС ОЛГОХ ТЭТГЭМЖ УРАМШУУЛАЛ | 2.2 | 2.2 | - | 100 |
| 3 | 81801-ҮДИЙН ЦАЙ ХӨТӨЛБӨР | 83.4 | 82.4 | 1.0 | 98.8 |
| 4 | 81834-БОЛОВСРОЛЫН СТАНДАРТ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ | 2,065.4 | 2,062.1 | 3.4 | 99.8 |
| 5 | 81835-СУРГАЛТЫН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ | 438.8 | 438.8 | 0 | 100 |
| | | 3,187.2 | 3,182.9 | 4.4 | |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2021 онд нэмэлт төсвийн дансаар нийтдээ 43.2 сая.төгрөгийн орлого орсон ба нэр данс зөрүү 0.7 сая төгрөгийн орлого орж зарлага гарсан бөгөөд 42.5 сая төгрөгийн орлого орж зориулалтын дагуу зарцуулсан байна.

***Хүснэгт3.Төсвийн гүйцэтгэлийн тайлан /нэмэлт/ /сая төгрөг/***

| ҮЗҮҮЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн |
|---|---|---|
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 42.5 | 42.5 |
| Хангамж, бараа материалын зардал | 14.0 | 14.0 |
| Эд хогшил худалдан авах, урсгал засвар | 3.8 | 3.8 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 18.8 | 18.8 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 5.9 | 5.9 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР, Нэмэлт санхүүжилтийн орлого | 42.5 | 42.5 |
| ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1.5 | 1.5 |
| Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 22.8 | 22.8 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 18.2 | 18.2 |

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Сүүлийн хоёр жил дараалан байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг тасалдуулж тайлагнаж байгаа нь ковид-19 цар тахлын нөлөөнөөс шалтгаалсан хичээл сургалтын байгууллагын үйл ажиллагаа доголдсоноос шалтгаалсан гэж тайлбарлаж байгаа боловч орлогыг бодитой төлөвлөж батлуулаагүй байгаа дутагдал байна. 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Мөрөн сумын ИТХ-ын хуралдаанаар 2021 оны төсвийг 2,952.8 сая төгрөгөөр баталсан бөгөөд аймгийн ИТХ-ын хуралдааны 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор төсвийг 3,155.9 сая төгрөг болгож 203.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгол хийсэн бол аймгийн засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/608 тоот захирамжаар 3187.2 сая төгрөг болгож 32.2 сая төгрөг бүгд 234.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Энэ нэмэгдлээр цалин, нийгмийн даатгалын шимтгэл 83.7 сая төгрөг, хангамж бараа материалын зардал 24.6 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 127.7 сая төгрөг, эмийн зардал 6.8 сая төгрөг, ХҮДХ зардал 19.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн, байр ашиглахтай холбоотой зардал 29.9 сая төгрөг, үдийн хоолны зардал 74.5 сая төгрөгөөр, томилолтын зардал 1.0 сая төгрөгөөр хасагдсан байна.

БШУ-ны сайдын 2021 оны 06 дугаар сарын 15-ний өдрийн А/222 дугаар тушаалаар сургуулийн сэтгэл зүйч ажиллуулж 3.9 сая төгрөгийн цалингийн зардал гаргасан байна. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолд зааснаар 2021 онд цалин, нийгмийн даатгалын шимтгэлээс бусад 863.8 сая төгрөгөөс 86.4 сая төгрөгийн төсвийг хэмнэлт гаргахаас 1.0 сая төгрөгийн төсөв татан төвлөрүүлсэн бөгөөд 85.4 сая төгрөгийн хэмнэлт гаргаагүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал байхгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт орсон өөрчлөлт байхгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна. Бидний хувьд зөвхөн санхүүгийн тайлангийн аудит хийж гүйцэтгэсэн болно.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүргэтэй.

Тайлант онд шилэн дансанд 151 мэдээлэл оруулах ёстойгоос 137 мэдээллийг цаг хугацаанд нь байршуулж, 9 мэдээллийн хугацаа хоцорсон, 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна. Шилэн данс сайтад байршуулсан мэдээллийн чанар стандартын шаардлага хангалтгүй зөвхөн тухайн хугацаанд тохируулан мэдээлэл оруулсан байна. Цаашид шилэн данс сайтад байршуулж байгаа мэдээллийн үнэн зөв, чанар стандартад анхаарах шаардлагатай болсон байна. Шилэн дансан дахь мэдээлэл жирийн хэрэглэгч бүхэнд ойлгомжтой, тодорхой байх шаардлагатай байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Засгийн газрын хувь оролцоо дансны санхүүгийн тайлан дахь үлдэгдэл 2,278.1 сая төгрөг байхад улсын бүртгэлийн гэрчилгээнд 695.5 сая төгрөг байгаа нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10.3-д "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 10.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр, бусад баримт бичгийг тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ" гэсэн заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд 852.2 сая төгрөгийн 15 төрлийн худалдан авалтыг худалдан авалтын хуульд заасан журамд зааснаар зохион байгуулсан байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн 1 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын үйл ажиллагааны орлого, зардлын төлөвлөгөөг боловсруулахдаа үндэслэлтэй, төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, хариуцлагатай байх зарчмуудыг мөрдөж тухайн үед Засгийн газраас гаргасан бодлого журамтай уялдуулан ажиллах шаардлагатай гэж үзлээ. Өөрийн орлогыг бодитой төлөвлөж бүрэн оруулах талаар санаачлагатай ажиллах.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 86.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 0.9 сая төгрөгийн алдааг залруулж, 85.4 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага, Шилэн дансны хуулийн хэрэгжилтээр 1 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Хөвсгөл аймгийн Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын дараах алдааг санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

1. Тайлант оны 0,9 сая төгрөгийн гэрэл цахилгааны зардлыг цэвэр бохир усны зардалд, бүртгэснийг залруулав.

4.2 Албан шаардлага

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолд зааснаар Хөвсгөл аймгийн Дэлгэрмөрөн цогцолбор сургууль нь цалин, нийгмийн даатгалын шимтгэл, төрөөс олгох дэмжлэгээс бусад тэвчиж болох зардлаас 10-аас доошгүй хувийн хэмнэлт буюу 85.4 сая төгрөгийг хэмнээгүй байх тул албан шаардлага өгсөн болно.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Шилэн данстай холбоотой асуудал**

**1.1. Илрүүлэлт:**

Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэл байршуулсан дүнг хянаж үзэхэд нийт хугацаа хоцорсон 9 мэдээлэл байна. Мөн байршуулсан мэдээллийн чанар стандарт хангалтгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1:2 мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх, 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**1.2. Өгсөн зөвлөмж:**

Хуулийн хугацаанд шилэн дансны мэдээллийг үнэн зөв чанар стандартад нийцүүлж мэдээлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР: /Э.БАТ-ЭРДЭНЭ/ 11/20

Огноо

АХЛАХ АУДИТОР /Г.ЭРДЭНЭЧИМЭГ/

Огноо

БИЗКОН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ /Л.ОТГОНБАЯР/

Огноо

БОЛОВСРУУЛСАН:

БИЗКОН АУДИТ ХХК-ЫН АУДИТОР ...................... / Ч.МӨНХБАЯР/

Огноо: 2022.02.26.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Дэлгэрмөрөн цогцолбор сургууль | 3 | 86.3 | 1 | 0.9 | 0 | 0 | 1 | 85,4 | 1 | 00 |